

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэс сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/68/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг:
BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Авирмэд

Утас: 70453799, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023. 02. 24 № УВА-2023/68/НА-СТА-ТЦЦЗ
танай _____-ны № _____-т

ТЭС СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.ЧОЙСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэс сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэс сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тэс сумын Засаг даргын тамгын газар нь анхан шатны баримтын бүрдэлгүй 14,522.2 мянган төгрөгийн 26 гүйлгээ хийсэн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэж, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

0200200408

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	14
4. Аудитын тайлан.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>54,434,478.00</u>	<u>105,992,943.00</u>
33	АВЛАГА	00.00	453,034.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	453,034.00
35	БАРАА МАТЕРИАЛ	54,434,478.00	105,539,909.00
354	Хангамжийн материал	42,434,478.00	65,558,578.00
35410	Бичиг хэргийн материал	820,500.00	871,600.00
35420	Аж ахуйн материал	8,456,778.00	9,376,778.00
35430	Сэлбэг хэрэгсэл	305,000.00	280,000.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	1,400,000.00
35450	Барилгын засварын материал	411,000.00	411,000.00
35470	Бусад хангамжийн материал	32,441,200.00	53,219,200.00
35600	Мал амьтад	12,000,000.00	39,981,331.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,391,086,194.48</u>	<u>3,645,855,503.01</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,391,086,194.48	3,645,855,503.01
392	Биет хөрөнгө	3,326,156,794.48	3,580,926,103.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,501,551,114.08	3,603,219,924.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	-462,308,915.66	-561,100,937.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	208,820,000.00	336,230,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-111,124,666.64	-91,927,111.13
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	235,355,066.00	349,652,080.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-173,102,930.25	-179,573,800.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,749,884.50	40,760,414.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-42,056,757.55	-36,348,467.15
39209	Зам, гүүрний байгууламж	50,000,000.00	50,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-50,000,000.00	-50,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,300,000.00	6,300,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,000,000.00	-5,260,000.04
39217	Ном	118,974,000.00	118,974,000.00
393	Биет бус хөрөнгө	64,929,400.00	64,929,400.00
39301	Программ хангамж	1,460,000.00	1,460,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,460,000.00	-1,460,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	64,929,400.00	64,929,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,445,520,672.48</u>	<u>3,751,848,446.01</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,790,831.00</u>	<u>250,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,790,831.00	250,000.00
413	Өглөг	2,790,831.00	250,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	554,407.00	00.00
4136	Бусад өглөг	2,236,424.00	250,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,236,424.00	250,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,442,729,841.48</u>	<u>3,751,598,446.01</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,442,729,841.48	3,751,598,446.01

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	484,321,503.00	484,321,503.00
51101	Өмч: - төрийн	484,321,503.00	484,321,503.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,130,093,024.03	2,439,008,498.56
51210	Өмнөх үеийн үр дүн	2,130,093,024.03	2,130,139,894.03
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	308,868,604.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	828,315,314.45	828,268,444.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,445,520,672.48	3,751,848,446.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	661,432,037.00	968,843,128.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	142,545,140.00	370,911,407.40
120	Нийтлэг татварын бус орлого	142,545,140.00	370,911,407.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	142,545,140.00	370,911,407.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,307,533.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	142,545,140.00	367,603,874.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	518,886,897.00	597,931,721.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,738,897.00	7,383,921.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	750,000.00	3,689,921.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,088,897.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,900,000.00	3,694,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	513,148,000.00	590,547,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	513,148,000.00	590,547,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	633,046,657.09	659,832,190.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	633,046,657.09	659,832,190.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	588,088,729.09	601,170,426.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	321,231,879.00	324,495,070.00
210101	Үндсэн цалин	321,231,879.00	266,272,215.00
210102	Нэмэгдэл	00.00	36,996,448.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	7,878,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	13,348,407.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,101,830.00	40,036,247.00
210201	Тэтгэврийн даатгал	37,759,151.64	32,417,288.68
210202	Тэтгэмжийн даатгал	770,419.59	1,035,349.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	616,335.81	828,279.46
210204	Ажилгүйдлийн даатгал	154,083.78	207,069.87

210205	Эрүүл мэндийн даатгал	2,801,839.18	5,548,259.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,234,935.00	27,619,770.00
210301	Гэрэл, цахилгаан	2,386,959.00	3,829,470.00
210302	Түлш, халаалт	24,184,156.00	22,709,316.00
210303	Цэвэр, бохир ус	2,663,820.00	1,080,984.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,467,489.00	40,671,610.00
210401	Бичиг хэрэг	4,205,100.00	3,439,300.00
210402	Тээвэр, шатахуун	24,455,140.00	34,150,170.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,537,900.00	1,550,740.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,047,000.00	1,531,400.00
210408	Бараа материал акталсны зардал	3,222,349.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,271,000.00	4,049,000.00
210604	Урсгал засвар	9,271,000.00	4,049,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,750,000.00	3,398,000.00
210702	Дотоод албан томилолт	4,750,000.00	3,398,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,021,901.00	1,683,477.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	648,250.00	560,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	174,705.00	174,705.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,746.00	193,072.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	477,000.00	407,500.00
210807	Газрын төлбөр	133,000.00	133,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	145,009,695.09	159,217,252.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,578,226.00	22,584,351.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	540,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	127,331,469.09	136,092,901.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,957,928.00	58,661,764.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,458,900.00	34,274,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,653,400.00	33,474,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	805,500.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	32,499,028.00	24,387,164.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,499,028.00	24,387,164.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	28,385,379.91	309,010,937.55
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	25,531,120.12	142,333.02
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	25,531,120.12	142,333.02
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-25,531,120.12	-142,333.02
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,854,259.79	308,868,604.53

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	518,886,897.00	601,239,254.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	3,307,533.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	3,307,533.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	3,307,533.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,307,533.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	518,886,897.00	597,931,721.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,738,897.00	7,383,921.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	750,000.00	3,689,921.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,088,897.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,900,000.00	3,694,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	513,148,000.00	590,547,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	513,148,000.00	590,547,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	518,886,897.00	530,039,254.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	518,886,897.00	530,039,254.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	473,928,969.00	471,377,490.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	326,649,206.00	326,481,494.00
210101	Үндсэн цалин	287,899,156.00	268,258,639.00
210102	Нэмэгдэл	00.00	36,996,448.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	7,878,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	38,750,050.00	13,348,407.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,736,130.00	41,043,688.00
210201	Тэтгэврийн даатгал	28,393,451.64	33,424,729.68
210202	Тэтгэмжийн даатгал	770,419.59	1,035,349.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	616,335.81	828,279.46
210204	Ажилгүйдлийн даатгал	154,083.78	207,069.87
210205	Эрүүл мэндийн даатгал	2,801,839.18	5,548,259.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,234,935.00	29,019,770.00
210301	Гэрэл, цахилгаан	2,386,959.00	3,829,470.00
210302	Түлш, халаалт	25,171,986.00	24,109,316.00
210303	Цэвэр, бохир ус	1,675,990.00	1,080,984.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,819,240.00	33,962,570.00
210401	Бичиг хэрэг	3,824,100.00	3,097,200.00
210402	Тээвэр, шатахуун	20,856,040.00	27,498,630.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,537,900.00	1,626,740.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	666,200.00	800,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	935,000.00	940,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,339,000.00	5,423,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,050,000.00	180,000.00
210602	Тавилга	2,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	10,289,000.00	5,243,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,750,000.00	3,398,000.00
210702	Дотоод албан томилолт	4,750,000.00	3,398,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,021,901.00	1,683,477.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	648,250.00	560,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	174,705.00	174,705.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,746.00	193,072.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	477,000.00	407,500.00
210807	Газрын төлбөр	133,000.00	133,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,378,557.00	30,365,491.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,987,557.00	29,649,491.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	391,000.00	716,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,957,928.00	58,661,764.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,458,900.00	34,274,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,653,400.00	33,474,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	805,500.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	32,499,028.00	24,387,164.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,499,028.00	24,387,164.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	71,200,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	71,200,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	71,200,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	71,200,000.00
223001	Бусад хөрөнгө	00.00	70,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	1,200,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-71,200,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	484,321,503.00	828,315,314.45	2,130,093,024.03	3,442,729,841.48
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	484,321,503.00	828,315,314.45	2,130,093,024.03	3,442,729,841.48
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	46,870.00	46,870.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	484,321,503.00	828,315,314.45	2,130,139,894.03	3,442,776,711.48
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-46,870.00	00.00	-46,870.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	308,868,604.53	308,868,604.53
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	484,321,503.00	828,268,444.45	2,439,008,498.56	3,751,598,446.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	593,855,333.00	569,923,169.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	523,855,333.00	499,923,169.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	489,547,733.00	465,648,569.00
210101	Үндсэн цалин	346,971,533.00	326,481,494.00
210102	Нэмэгдэл	326,243,033.00	268,258,639.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	36,996,448.00
		00.00	7,878,000.00

210105	Гэрээт ажлын хөлс	20,728,500.00	13,348,407.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,048,100.00	41,043,688.00
210201	Тэтгэврийн даатгал	44,048,100.00	33,424,729.68
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,035,349.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	828,279.46
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	207,069.87
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	5,548,259.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,299,800.00	29,019,770.00
210301	Гэрэл, цахилгаан	5,277,400.00	3,829,470.00
210302	Түлш, халаалт	23,490,000.00	24,109,316.00
210303	Цэвэр, бохир ус	532,400.00	1,080,984.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,646,800.00	31,602,570.00
210401	Бичиг хэрэг	3,179,000.00	3,097,200.00
210402	Тээвэр, шатахуун	25,141,800.00	25,138,630.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,588,600.00	1,626,740.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	937,400.00	940,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,436,500.00	5,404,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,380,000.00	1,380,000.00
210604	Урсгал засвар	4,056,500.00	4,024,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,407,100.00	3,398,000.00
210702	Дотоод албан томилолт	3,407,100.00	3,398,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,721,400.00	1,683,477.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	560,000.00	560,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	180,000.00	174,705.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	193,072.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	80,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	408,200.00	407,500.00
210807	Газрын төлбөр	133,200.00	133,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27016500.00	27015570.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,600,000.00	26,599,570.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	416,500.00	416,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34307600.00	34274600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,307,600.00	34,274,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,474,600.00	33,474,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	833,000.00	800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	70,000,000.00	70,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	70,000,000.00	70,000,000.00
223001	Бусад хөрөнгө	70,000,000.00	70,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	593,855,333.00	569,923,169.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	593,855,333.00	566,615,636.00

132001	Орон нутгийн төсвөөс	593,855,333.00	566,615,636.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		
		00.00	3,307,533.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,307,533.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО		
		34.00	34.00
620001	Удирдах ажилтан	13.00	13.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,928,921.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,928,921.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,928,921.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,360,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,360,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,219,000.00
210604	Урсгал засвар	1,219,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3349921.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,049,921.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6928921.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,928,921.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,689,921.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,239,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тэс сумын Засаг даргын тамгын газар нь иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэс сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тэс сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 306,327.7 мянган төгрөгөөр буюу 8.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага		453.03	453.03
Урьдчилгаа			
Бараа материал	54,434.5	105,539.9	51,105.4
Үндсэн хөрөнгө	3,391,086.1	3,645,855.5	254,769.3
Нийт хөрөнгө	3,445,520.6	3,751,848.4	306,327.7
Өр төлбөр	2,236.4	250.0	-1,986.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,442,729.8	3,751,598.4	308,868.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,445,520.6	3,751,848.4	306,327.7

Бараа материалын дансны үлдэгдэл 105,539.9 мянган төгрөг болж 51,105.4 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангаас өвс, тэжээл авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,645,855.5 мянган төгрөг болж 254,769.3 мянган төгрөгөөр өссөн нь шинэ хөдөө төслийн хүрээнд иж бүрэн трактор, төсвийн хөрөнгөөр машин худалдаж авсан зэргээс шалтгаалж нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,751,598.4 мянган төгрөг болж 308,868.6 мянган төгрөгөөр өссөн нь нь үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 573,628.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 573,628.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 20,226.9 мянган төгрөгөөр өсгөж 593,855.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 593,855.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 593,855.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 590,547.8 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,307.5 мянга нийт

590,855.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 569,923.2 мянган төгрөгийг зарцуулж, 23,932.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 569,923.2 мянган төгрөг буюу 95.9 хувьтай байгаа нь зардлыг 23,932.1 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101	227,163.2	227,002.0	161.1	99.9
2	80106	144,927.4	133,435.5	11,491.8	92.0
3	80111	32,156.3	31,843.7	312.5	99.0
4	80112	57,798.7	45,865.4	11,933.2	79.3
5	80205	250.0	250.0		100.0
6	80802	833.0	800.0	33.0	96.0
7	80815	33,474.6	33,474.6		100.0
8	80918	70,000.0	70,000.0		100.0
9	81102	18,500.0	18,499.5	0.4	99.9
10	81507	3,500.0	3,500.0		100.0
11	82212	800.0	800.0		100.0
12	82801	4,000.0	4,000.0		100.0
13	81549	600.0	599.9	0.01	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗГНХ, ЗДНХ хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгө 3,689.9 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,694.0 мянга нийт 7,383.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр шатахуунд 2,360.0 мянга, ахмадын үйл ажиллагааны зардалд 1,300.0 мянга, урсгал зардалд 1,219.0 мянга, гэр бүл хүүхдийн үйл ажиллагааны зардалд 300.0 мянга, талбайн тусгаарлалтын зардалд 1,749.9 мянган төгрөгийг зарцуулж 455.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тэс сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэс сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 5.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 659.8 сая төгрөгийн 1.0 хувь буюу 6.6 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 5.3 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Тэс сумын Засаг даргын тамгын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 128, байршуулаагүй 21, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Тэс сумын Засаг даргын тамгын газар нь Тэс сумын Засаг даргын тамгын газар нь шилэн дансны цахим хуудаст 148,182.9 мянган төгрөгийн 9 мэдээлэл, 14,130.4 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулах 49 шийдвэрийг байршуулаагүй зөрчилд албан шаардлага өглөө.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тэс сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт мянган төгрөгийн 176,835.5 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 162,313.3 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 14,522.2 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

5.2 Албан шаардлага

Тэс сумын Засаг даргын тамгын газар нь шилэн дансны цахим хуудаст 148,182.9 мянган төгрөгийн 9 мэдээлэл, 14,130.4 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулах 49 шийдвэрийг байршуулаагүй зөрчилд албан шаардлага өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тэс сумын Засаг даргын тамгын газар нь анхан шатны баримтын бүрдэлгүй 14,522.2 мянган төгрөгийн 26 гүйлгээ хийсэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэж, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэлгүй 26 гүйлгээ хийсэн байна	1	14,522.2					1	14,522.2				
Дүн	1	14,522.2					1	14,522.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
шилэн дансны цахим хуудаст мэдээлэл байршуулаагүй	1	162,313.3					1	162,313.3				
Дүн	1	162,313.3					1	162,313.3				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн												
Нийт дүн	1	162,313.3					1	162,313.3				

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  /Б.АВИРМЭД/